



Ag Re | ХӨДӨӨ АЖ АХУЙН
ДАВХАР ДААТГАЛ ХК

ЖИЛИЙН ТАЙЛАН
2017



МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах, санхүүгийн зах зээлийн тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадвар бүхий давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх их үйлсэд хамтран ажилладаг эрхэм харилцагч, байгууллага Та бүхэндээ Монгол Улсын Сангийн яамны нэрийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Даатгалын салбар бол санхүүгийн тулгуур салбаруудын нэг бөгөөд тухайн улсын эдийн засгийн хөгжил, худалдаа арилжаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, даатгалын компаниудын эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх, зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, олон улсын даатгалын мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр үр дүнтэй ажиллаж байна.

Түүнчлэн 2017 онд Монгол Улсын Засгийн газраас батлагдсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий салбар болгон төлөвшүүлэх” зэрэг төрийн бодлого зорилтын ажлын хүрээнд үндэсний давхар даатгалын тогтолцоог бүрдүүлэх, валютын гадагшлах урсгалыг бууруулах, даатгалын эрсдэлийг нэгдсэн журмаар олон улсад гаргаж, зардлыг бууруулах Засгийн газар болон салбарын бодлогыг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байгаа юм. Давхар даатгалын тогтолцоог бий болгосноор дотоодын даатгагчдын эрх ашгийг хамгаалж, даатгалын дотоод зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэн, бага зардлаар эрсдэлийг хамтран хариуцах тогтолцоог бүрдүүлээд зогсохгүй, улс орны эдийн засаг болон даатгалын салбарын хөгжилд өндөр хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ

МЭНДЧИЛГЭЭ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хамт олон болон өөрийн нэрийн өмнөөс эрхэм танд энэ өдрийн мэндийг хүргэе.

Манай компани нь Монгол Улсын анхны давхар даатгалын компанийн хувьд хөдөө аж ахуйн салбарыг даатгалын аргаар эрсдэлээс хамгаалах ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа билээ.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК 2015 оноос хойш малын индексжүүлсэн даатгалыг Монгол орон даяар амжилттай зохион байгуулж, 2017 онд МИД-д даатгуулсан малчин өрхийн тоо нийт малчин өрхийн 15.3%-ийг эзэлсэн нь зөвхөн манай компанийн хувьд ч бус уг даатгалын түүхэн дэх хамрагдалтын хувь хэмжээний хамгийн оргил цэг боллоо.

Бид олон улсын даатгалын салбарын хурдацтай хөгжилтэй хөл нийлүүлэх хэрэгцээ шаардлага, Монгол Улсын эдийн засгийн бодлого, Засгийн газрын нэр бүхий олон хөтөлбөрүүдтэй нийцүүлэн үйл ажиллагаагаа өргөжүүлж, “Үндэсний давхар даатгалын компани” болох томоохон зорилго өмнөө тавин, холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Түүнчлэн уул уурхайн бус салбарын аж ахуйн

нэгжүүдийг гадаад улс орнуудад бүтээгдэхүүнээ экспортлоход нь төлбөр хүлээн авахтай холбоотой эрсдэлийг бууруулж, дэмжлэг үзүүлэх зорилгоор Экспортын зээлийн даатгал хэмээх санхүүгийн шинэ үйлчилгээг эх орондоо нэвтрүүлэх ажлыг манай компани хариуцан ажиллаж байна.

Бидний урдаа тавьсан зорилгыг дэмжиж, үнэтэй туршлагаасаа харамгүй хуваалцдаг хамтран ажиллагч байгууллагууд, аймаг, сумдын холбогдох ажилтнууд, даатгалын төлөөлөгчид болон эрсдэлээс өөрсдийн бизнесээ хамгаалж, даатгуулж буй баялаг бүтээгч харилцагчдадаа ямагт талархаж байдгаа илэрхийлье. Хийж буй ажил, амжилтынхаа үр дүнг эх орон, хэрэглэгч олондоо хүргэж, даатгалын салбарын хөгжлийг шинэ шатанд аваачих, даатгуулагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцэж, олон улсын стандартыг хангасан давхар даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлэн, амжилттай хэрэгжүүлэхийн тулд манай хамт олон цаг ямагт сэтгэл зүрх, гар нийлж, хичээнгүйлэн ажиллах болно.

Эрхэм танд болон танай гэр бүлд эрүүл энх байж, ажил үйлс нь дээшлэн дэвжиж, амьдрал зүтгэл нь өрнөн жаргаж байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г. Энхтайван

Г.ЭНХТАЙВАН

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд үндэслэн Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тогтоолоор байгуулагдсан.

Монгол Улсад давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

АЛСЫН ХАРАА

- Монгол Улсын даатгалын тогтолцоог олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангана.


ЭРХЭМ ЗОРИЛГО

- Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарыг бүхэлд нь хамарсан эрсдэлийг хамгийн бага түвшинд бууруулах замаар иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих

- Хөдөө аж ахуй, санхүүгийн салбарын хөгжлийг шинэ шатанд авчрах.

ҮНДСЭН ЗОРИЛГО

- Даатгагч, даатгуулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай давхар даатгалын бүтээгдэхүүнийг санал болгон, худалдан борлуулах замаар оролцогч талуудын нийтлэг эрх ашгийг хамгаалж хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг өсгөхөд оршино.



“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН БҮТЭЦ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 5 газар нэгжтэй. Үүнд: Андеррайтингийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Экспортын даатгалын газар, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар, Захиргаа удирдлагын газар орно.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй /үүнд хараат бус 3 гишүүн/. ТУЗ-ийн дарга нь Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт болно.



ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

2014

"Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК нь 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Засгийн газрын 280 дугаар тогтоолоор үүсэн байгуулагдав.



2016

Улаан буудайн тариаланг нэр бүхий эрсдэлээс хамгаалах "Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал"-ын бүтээгдэхүүнийг боловсруулж, дотоодын зах зээлд нэвтрүүлэв.



2017

Олон улсын Экспортын зээлийн даатгалын Бернийн холбооны гишүүн болов.



Малын индексжүүлсэн даатгалын 10 дахь удаагийн борлуулалтыг анх удаа бие даан орон даяар амжилттай зохион байгуулав.

2015



Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хамтын ажиллагаагаар хэрэгжүүлж буй Экспортыг дэмжих төслийн бүрэлдэхүүн 1-ийг хэрэгжүүлж, Экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг зэх зээлд нэвтрүүлэхээр ажиллаж эхлэв.

2017

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2017 онд манай компанийн нийт хөрөнгө өмнөх оноос **22 хувиар** буюу **7.87 тэрбум** төгрөгөөр өсөж нийт **43.39 тэрбум** төгрөгт хүрсэн нь Монгол Улсын даатгалын салбарын **17.7 хувийг** эзэлж байна. Компанийн нөөц сан **45 хувиар** өсөж **19.4 тэрбум** төгрөгт хүрсэн ба **2017 онд** өмнөх оноос **45 хувиар** илүү ашиг олж нийт ашиг **4.3 тэрбум** төгрөгт хүрлээ.

Малын индексжүүлсэн даатгалын хамрагдалт өмнөх оноос **29 хувиар** өсөж, **24,148** малчин өрхийг даатгаж **2.329 тэрбум** төгрөгийн хураамж төвлөрүүлсэн бол туршилтын журмаар хэрэгжүүлж буй Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд нийт **1,067 га** талбайг даатган **46.3 сая** төгрөгийн хураамжийг төвлөрүүллээ.


ЦЭВЭР АШИГ




НИЙТ ХӨРӨНГӨ



ДААТГАЛЫН ХУРААМЖ /тэрбум төгрөг/



НИЙТ НӨӨЦ САН 2015-2017 /тэрбум төгрөг/



Алдагдлаас хамгаалах сан
Хамтын эрсдэлийн сан
Эрсдэлээс хамгаалах сан

МИД-ЫН 2017 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн гурав дахь жилийн борлуулалт, МИД-ын арван хоёр дахь борлуулалтын улирал 2017 оны 2 дугаар сарын 01-нд 21 аймгийн нийт 330 суманд эхэлснээс хойш 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд оролцогч даатгагчид болох “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК-ууд болон

зуучлалаар Төрийн банк, ХААН БАНК оролцон нийт **24,148 малчин** өрхтэй Малын индексжүүлсэн даатгал /МИД/-ын гэрээг байгуулж, **2 тэрбум 329 сая** төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 15.3%-ийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны даатгуулсан малчин өрхийн тооноос 5,410 өрхөөр, даатгалын хураамжийн орлого 555.0 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тайлант онд МИД-ын эрсдэл даах чадвар нь 8 тэрбум 977.0 сая төгрөг байв.




“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь ХААН БАНК болон Төрийн банкаар дамжуулан МИД-ын хураамжийн зээл болон МИД-д малаа даатгуулсан малчдад хөнгөлөлттэй зээлийг олгож байна.

МИД-ЫН БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН



5,686,424
ДААТГАЛД ХАМРАГДСАН
НИЙТ МАЛ **9.23%**

АЙМГИЙН МАЛЧИН ӨРХӨД МИД-Д ДААТГУУЛСАН МАЛЧИН ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



Даатгалд хамрагдсан малчин өрхийн нийт малчин өрхөд эзлэх хувь нь 15.3% бөгөөд энэ нь өнгөрсөн оноос 3.06%-аар өссөн үзүүлэлттэй байна.

МИД-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУРААМЖИЙН ОРЛОГО /сая төгрөгөөр/



НӨХӨН ТӨЛБӨР - МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ

Үндэсний статистикийн хорооноос 2017 оны хагас жилийн мал тооллогын албан ёсны мэдээг хүлээн авч 2016 онд малаа даатгуулсан даатгуулагч нарт олгох нөхөн төлбөрийг тооцоолов. Уг тооцооллоор Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгууд болон Улаанбаатар хотын Налайх дүүрэгт малын индексжүүлсэн даатгалын нэгдүгээр босго үзүүлэлт давсан тул дээрх 10 аймгийн 33 сум, 1 дүүрэгт нийт 806 малчин өрхөд 79.6 сая төгрөгийн нөхөн төлбөр олгон ажиллалаа.

Хэдийгээр олгож буй нөхөн төлбөрийн дүн бага боловч Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ зэрэг хорогдол бага гардаг, өмнө нь маш бага хэмжээгээр нөхөн төлбөр олгож байсан болон нөхөн төлбөрийн тохиолдол гарч байгаагүй аймгуудад хорогдол өндөр гарсан байна. Тухайлбал газар тариалан зонхилдог Сэлэнгэ аймгийн Хушаат суманд хонины хорогдол 33.2 хувь гарч аймгийн хоёрдугаар босго үзүүлэлт болох 25 хувиас давсан байна.

20,849
малчин өрх

3.7 тэрбум төгрөг

МИД-ын 2006 оноос хойш олгосон нийт нөхөн төлбөр


НЭРЛЭСЭН ЭРСДЭЛТ УЛААН БУУДАЙН ДААТГАЛЫН 2017 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН

Үндэсний хүнсний стратегийн бүтээгдэхүүн болох улаан буудайн тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийг байгаль, цаг уурын болон бусад нэр бүхий эрсдэлээс шалтгаалан ургац алдаж, эдийн засгийн хохирол хүлээхээс хамгаалах зорилгоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж, 2016 оноос эхлэн туршилтын журмаар хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү даатгалд даатгуулагч нь өөрийн талбайгаа сонгон даатгуулах боломжтой бөгөөд даатгуулсан талбайн 1 га-аас дунджаар хураах ургацын алдагдлаа даатгуулж байгаа юм.

Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалд даатгасан эрсдэлийн 20 хувийг дотооддоо даатгаж, үлдсэн 80 хувийг СКОР /SCOR/ давхар даатгалын компанид даатгуулахаар “Хөдөө аж ахуйн давхар даатгалын хувь оролцооны гэрээ”-г байгуулсан. Олон улсын давхар даатгалын СКОР /SCOR/ компанитай хамтран туршилтын журмаар хийж буй нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалыг 2016 онд “Бодь даатгал” ХХК, 2017 онд “Ард даатгал” ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн юм.

ЭРСДЭЛИЙН ХУВААРИЛАЛТ- 2017



Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын хураамжийн орлого:

2016-2017 онд даатгуулагчийн нийт **649,672,247** төгрөгийн үнэлгээ бүхий **1,067 га** талбайг даатгаж, **59,808,506** төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлээ.

2016 онд | Даатгуулсан талбай - **250 га**


Сэлэнгэ аймгийн Хушаат сумын аж ахуйн нэгжийг даатгав.

2017 онд | Даатгуулсан талбай - **817 га**

2017 онд Үрийн тариалалт хийх зөвшөөрөл авсан болон таваарын улаан буудай тариалсан аж ахуйн нэгжүүдийг даатгав.

НӨХӨН ТӨЛБӨР - НЭРЛЭСЭН ЭРСДЭЛТ УЛААН БУУДАЙН ДААТГАЛ

2016-2017 ОНЫ НЭРЛЭСЭН ЭРСДЭЛТ УЛААН БУУДАЙН
ДААТГАЛЫН ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН /сая төгрөгөөр/



Энэ онд нийт нутгаар хуурай гандуу байсан төдийгүй даатгалд хамрагдсан Төв аймгийн Жаргалант сум, Эрдэнэсант сум, Булган аймгийн Хутаг-Өндөр сум, Сэлэнгэ аймгийн Хушаат сумдад хуурай халуун болж, ургацын хэмжээ буурсан юм. Иймд дээрх сумдын даатгалд хамрагдсан нийт дөрвөн аж ахуйн нэгжид **211,173,419** төгрөгийн нөхөн төлбөр олголоо.

2017 ОНЫ НӨХӨН ТӨЛБӨРИЙГ “ХӨДӨӨ АЖ АХУЙН ХУВЬ ОРОЛЦООНЫ ГЭРЭЭ”-НИЙ ДАГУУ ОЛГОЛОО.

“Ард даатгал” ХХК- 3%
6,335,202 төгрөг

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК- 17%
35,899,481 төгрөг

СКОР /SCOR/ олон улсын
давхар даатгагч- 80%

168,938,736 төгрөг

ТАРИАЛАНГИЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК тариалангийн уламжлалт даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулан туршилтын журмаар хэрэгжүүлэхийн зэрэгцээ 2017 оноос тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор олон улсын давхар даатгалын СКОР /SCOR/ компани болон цаг

уурын мэдээллийн сан /платформ/ ашиглан загварчлал боловсруулдаг олон улсын Цельсиус Про /Celsius Pro/ компанитай хамтран тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах, загварчлах ажлыг эхлүүлээд байна.

ТАРИАЛАНГИЙН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ДАВУУ ТАЛ

Үйл ажиллагааны
зардал бага

Хохирол үнэлгээ
хийхэд цаг хэмнэдэг

Цаг уурын станц болон
хиймэл дагуулын
мэдээллийг ашиглан,
агрономийн шинжлэх
ухаанд суурилсан
загварчлал гаргадаг

Зан төлөвийн эрсдэлийг
(moral hazard) бууруулна.


ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ХҮНД МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ДААТГАЛ

Манай компани нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Атарын III аян”-ы хүрээнд “Газар тариалангийн техникийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм” лизинг ХХК-аас “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-аар дамжуулан түрээсэлж буй газар тариалангийн техник, тоног төхөөрөмжүүдийг даатгах

ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Уг төслийн хүрээнд ОХУ-аас нийт 10.0 сая ам.долларын үнэ бүхий машин механизм, тоног төхөөрөмж худалдан авсан бөгөөд 109 аж ахуйн нэгж түрээсээр тоног төхөөрөмж авсныг анхлан даатгагч “Ард даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК-аар дамжуулан давхар даатгаад байна.


ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Энэхүү ажлын хэсэгт “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн төлөөлөл орж, хуулийн урьдчилан тандан судлах судалгаа, хуулийн эдийн засгийн тооцоолол судалгааг хийхэд оролцож, тариалангийн даатгалын хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөлд саналаа өгч ажиллаж байна. Мөн хуулийн ажлын хэсгийн

хүрээнд олон улсын зөвлөхүүд ирж, улс орнуудад хэрэгжиж буй тариалангийн даатгалын бүтээгдэхүүн болон холбогдох хуулийн туршлагыг хуваалцах, мэргэжлийн зөвлөгөөнүүдийг өгөхөд компанийн төлөөлөл хамтарч ажиллалаа.

ЭНЭХҮҮ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ГАРАХ АЧ ХОЛБОГДОЛ:




ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ - ЭКСПОРТЫН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ

Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банктэй хамтран уул уурхайн бус салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлж байгаа


бөгөөд уг төслийн хүрээнд экспортлогчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилготой “Экспортын зээлийн даатгал” хэмээх санхүүгийн шинэ үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх ажлыг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Экспортын даатгалын газар хариуцан ажиллаж байна.

2016-2017 ОНЫ ЭКСПОРТ /сая төгрөгөөр/



Экспорт 2017 онд 6200.6 сая ам.долларт хүрч 2016 оны гүйцэтгэлээс 1284.3 сая ам.доллараар буюу 27.4 хувиар өссөн байна.


2017 ОНЫ ЭКСПОРТЫН БҮТЭЦ



Экспортын бүтцийг авч үзвэл энэ 2017 онд нийт экспортын 79.6 хувь эрдэс бүтээгдэхүүнд; 9.6 хувь алтны экспортод, 5.4 хувь нэхмэлийн материал болон нэхмэл эдлэлийн экспортод тус тус ногдож байна.

• Уул уурхайн бүтээгдхүүн • Уул уурхайн бус бүтээгдхүүн

УУЛ УУРХАЙН БУС САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ЭКСПОРТЛОГЧДЫН АСУУДАЛ



ЭКСПОРТЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД



Монгол Улс 2017 онд дэлхийн 69 оронд бараа экспортлов.

БОГИНО ХУГАЦААТ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ

Богино хугацаат нийлүүлэгчийн зээлийн даатгал нь зээлдэгчийнхээ төлөх ёстой өр, зээлийн төлбөрөө төлөхгүй байхаас үүсэх хохирлоос дансны авлагаа даатгахыг хүссэн бизнесийн байгууллагуудад зориулсан даатгал юм.

Арилжааны эрсдэлд

- Худалдан авагч түр зуур төлбөрийн чадваргүй болох
- Худалдан авагч дампуурах
- Төлбөрийн удаашралт

Улс төрийн эрсдэлд

- Худалдан авагчийн Засгийн газрын шийдвэрийн дагуу төлбөрийг зогсоох
- Валютын ханшийн үл хөрвөх байдал
- Худалдан авагч компанийг улсын мэдэлд авах,
- Хөрөнгийг албадан хураах
- Экспорт, импортын лицензийг цуцлах, сунгахгүй байх, хүчингүй болгох
- Дайн, иргэний дайн, бослого, үймээн самууны улмаас төлбөр төлөлт хойшлох

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДААТГАЛ

Эргэлтийн хөрөнгийн даатгал гэдэг нь экспортлогч зээл авсан банкиндаа зээлээ төлж чадаагүй байх эрсдэлээ хамгаалсан даатгал юм. Өөрөөр хэлбэл экспортлогч нь даатгалын компанид даатгуулсан баталгаа зээлийн барьцаа хөрөнгөнд тооцуулж болох давуу талтай.

Даатгах эрсдэлүүд

- Экспортлогч санхүүгийн байгууллагаас авсан зээл
- Экспортлогч төлбөрийн чадваргүй болох


ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДААТГАЛ

Экспортлогч эргэлтийн хөрөнгийн даатгалын гэрээг барьцаалан банкнаас эргэлтийн хөрөнгийн зээл авах бөгөөд экспортлогч буюу зээлдэгч зээлээ төлөхгүй байх эрсдэлээс банк болон бусад санхүүгийн байгууллагыг хамгаална.

БОГИНО ХУГАЦААТ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЗЭЭЛИЙН ДААТГАЛ

Экспортын гэрээний дагуу төлбөр хийгдэхгүй байх эсвэл гэрээний гүйцэтгэл, цуцлалт зэргээс үүдэн гүйцэтгэлийн зардлыг нөхөж чадахгүй байх эрсдэлээс экспортлогчийг хамгаална.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧ ТАНАА:

АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ. Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын /СТОУС/ дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

ДҮГНЭЛТ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан хязгаарлалттай дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

АУДИТОРЫН ХАРИУЦЛАГА

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн

эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

БУСАД ЗҮЙЛ

Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангууд нь өөр аудитороор баталгаажуулагдсан бөгөөд 2017 оны 3 дугаар сарын 30-ний өдөр өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчийн захиалгаар аудитыг гүйцэтгэн гагцхүү Компанийн хувьцаа эзэмшигчид зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно..

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

Петр Марки

Захирал

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр /мян.төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31	2016.12.31	2017.12.31
ХӨРӨНГӨ			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,509,842.9	231,318.5	495,187.1
Даатгалын авлага	156,007.2	128,952.9	20,720.7
Бусад санхүүгийн хөрөнгө	376,121.7	721,782.0	244,794.3
Санхүүгийн бус хөрөнгө			
Татвар НДШ-ийн авлага			
Бараа материал	3,133.3	8,311.5	
Урьдчилж гарсан зардал /тооцоо	215,604.0		6,802.9
Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	218,737.3	8,311.5	6,802.9
Хөрөнгө оруулалт			
Хадгаламж, хадгаламжийн сертификат		17,889,431.4	39,172,702.6
Засгийн газрын үнэт цаас	16,997,271.2	14,999,930.9	2,462,700.5
Хөрөнгө оруулалтын дүн	16,997,271.2	32,889,362.3	41,635,403.1
Даатгалын хөрөнгө			
Давхар даатгалын хойшлогдсон хураамж		428,088.9	205,193.1
Даатгалын хөрөнгийн дүн		428,088.9	205,193.1
Үндсэн хөрөнгө	350,869.5	639,221.1	363,228.9
Биет бус хөрөнгө	6,930.0	467,660.1	423,299.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	26,615,779.8	35,514,697.3	43,394,630.0

ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31	2016.12.31	2017.12.31
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Даатгалын өглөг			101,997.9
Санхүүгийн бус өр төлбөр			
Цалингийн өглөг		-	
Татвар НДШ-ийн өглөг	39,342.2	21,606.4	131,848.7
Бусад БХӨТ	981,600.0	2,730.7	105,103.5
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	1,020,942.2	24,337.0	338,950.1
Нөөц сан			
Хамтын эрсдлийн сан	591,056.6	846,425.9	1,165,807.3
Эрсдлээс хамгаалах сан	513,195.0	3,065,790.7	3,270,696.4
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц		1,008,701.8	460,217.3
Нөөц сангийн дүн	1,104,251.6	4,920,918.4	4,896,721.0
Өр төлбөрийн нийт дүн	2,125,193.8	4,945,255.5	5,235,671.1
ЭЗДИЙН ӨМЧ			
Эздийн өмч	15,000,000.0	15,000,000.0	15,000,000.0
Эздийн өмчийн бусад хэсэг	86,476.6	684,332.9	489,264.4
Алдагдлаас хамгаалах сан	7,000,000.0	9,500,000.0	15,000,000.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2,404,109.0	5,385,109.0	7,669,694.5
Эздийн өмчийн дүн	24,490,586.0	30,569,441.9	38,158,958.9
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	26,615,779.8	35,514,697.3	43,394,630.0

ОРЛОГЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр /мян.төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31	2016.12.31	2017.12.31
Нийт хураамжийн орлого		994,613.4	1,851,622.7
Давхар даатгалын хураамж	-	(352,810.9)	(800,423.2)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	-	641,802.6	1,051,199.5
Нийт төлсөн нэхэмжлэл		4,613.8	
Даатгалын хураамжийн орлогын дүн		637,188.8	1,051,199.5
Даатгалын нөөцийн өөрчлөлт, нийт дүнгээр	(513,195.5)	(367,344.2)	(206,218.8)
Давхар даатгалын комиссын орлого		2,200.5	8,339.0
Хөрөнгө оруулалтын орлого	3,356,554.3	4,439,231.0	5,814,162.1
Бусад орлого	-	510.0	91,777.7
Даатгалын хураамжийн бус орлогын дүн	3,356,554.3	4,441,941.5	5,914,278.8
Даатгалын орлогын дүн	2,843,358.8	4,711,786.1	6,759,259.5
Үйл ажиллагааны зардал	(992,246.5)	(1,534,775.4)	(1,908,232.0)
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	1,851,112.3	3,177,010.7	4,851,027.5
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(53.0)	(392.0)	(127,334.5)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,851,059.3	3,176,618.7	4,723,693.0
Орлогын татварын зардал	114,576.8	195,620.5	404,011.5
Татварын дараах ашиг (алдагдал)	1,736,482.5	2,980,998.2	4,319,681.6

ГАДААД ТҮНШҮҮД:

SCOR

 Swiss Re

LLOYD'S

berneunion 

hannover re®

CelsiusPro 
Professional Weather Protection


KazakhExport

 **RUSSIAN
REINSURANCE
COMPANY**

ДОТООД ТҮНШҮҮД:

 **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

 **ҮНДСЭНИЙ
СТАТИСТИК**

 **МОНГОЛ ДААТГАЛ**
MONGOL REINSURANCE COMPANY

ARD

 **ХААН
ДААТГАЛ**

 **МОНРЕ
ДААТГАЛ**

 **БОДЬ ДААТГАЛ**
САЙН САЙХНЫГ ИТГЭЛЭЭР ХАМГААЛНА

 **MIG**
Since 1997

 **ТЭНГЭР
ДААТГАЛ**

 **ПРАКТИКАЛ
ДААТГАЛ**

 **НОМИН
ДААТГАЛ**

 **ХААН БАНК**

 **ТӨРИЙН БАНК**

 **МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК**



☎ (+976) 7577 - 0002
✉ info@agreinsurance.mn
🌐 www.agreinsurance.mn
📘 /www.agreinsurance.mn
🐦 /AgReinsurance

ХАЯГ:
Business Tower, 20 давхар
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
5 дугаар хороолол, Чингисийн өргөн чөлөө, 10 Б байр
(14251) Улаанбаатар хот, Монгол Улс

